



СОЁМБОМ ЭДЭЭ

ӨДӨР ТУТМЫН ЦАХИМ СОНИН

МОНГОЛ УЛСЫНХАА ТӨЛӨӨ ЗҮТГЭЭ!

№115 /329/

2022.06.27

Цаг үе, үйл явдал

ҮНДСЭН ХУУЛИЙН ЦЭЦИЙН ГИШҮҮДЭД ХҮНДЭТГЭЛ ҮЗҮҮЛЭВ



Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн 30 жилийн ойг тохиолдуулан өнгөрсөн Бямба гарагт Үндсэн хуулийн цэцийн дарга Н.Чинбат тэргүүтэй төлөөлөгчдийг Монгол Улсын Засгийн газрын гишүүн, Батлан хамгаалахын сайд Г.Сайханбаяр хүлээн авч хүндэтгэл үзүүлээ.

Энэхүү арга хэмжээнд Батлан хамгаалахын дэд сайд Б.Баярмагнай, ЗХЖШ-ын Нэгдүгээр орлогч дарга бригадын генерал С.Ганбямба, Батлан хамгаалахын Ерөнхий хянан шалгагч бригадын генерал Ж.Болдбаатар, БХЯ-ны СБТГ-ын дарга хурандаа Ч.Гандирваа, ТЗУГ-ын дарга хурандаа С.Ванчинхүү нар байлцлаа.

Монгол Улс 1924, 1940, 1960, 1992 онуудад Үндсэн хуулиа дөрвөн удаа хэлэлцэн баталсан түүхтэй билээ. Энэ жил шинэ Үндсэн хууль батлагдсаны 30 жилийн ой тохиож байгаатай холбогдуулан Үндсэн хуулийн цэцийн гишүүдийг ийнхүү хүлээн авч хүндэтгэл үзүүлж буй юм.

Арга хэмжээний үеэр “Монгол Улсын батлан хамгаалах бодлого, эрх зүйн шинэчлэл”, “Монгол Улсын Зэвсэгт хүчний өнөөгийн байдал, хөгжлийн чиг хандлага”-ын талаар дэлгэрэнгүй танилцуулж, харилцан санал солилцов. Мөн Үндсэн хуулийн цэцийн гишүүд Зэвсэгт хүчний 084 дүгээр ангийн хээрийн сургалтын төвд зочлон Зэвсэгт хүчинд ашиглаж буй зарим төрлийн зэвсэг, техниктэй танилцлаа.

МЭНДЧИЛГЭЭ



хэрэгслээр нөхөн хангаж, тусгай мэргэжлийн сургалт бэлтгэлийг явуулж эхэлснээр Химийн цэрэг хэмээх шинэ төрөл мэргэжлийн цэрэг бий болсон түүхтэй билээ.

Химийн цэргийн үүсэл, хөгжил, дайчин уламжлал, бүтээлч үйл ажиллагаа нь Зэвсэгт хүчний хөгжлийн бүхий л үе шаттай салшгүй холбоотой бөгөөд баярын энэ өдөр эх орон, төр, ард түмнийхээ өмнө өргөсөн тангарагтаа үнэнчээр зүтгэж, монгол цэргийн шилдэг уламжлал, дайчин замналыг баяжуулж буй Та бүхнийхээ бахдам түүх, бахархам амжилтыг онцлон тэмдэглэхэд таатай байна.

Зэвсэгт хүчний Химийн цэрэг нь өнөө цагт бие бүрэлдэхүүнийг сурган дадлагажуулах, үйлдвэрлэлийн осол, хүн, малын гоц халдварт өвчин, байгалийн гамшгаас хүн ам, эд баялгийг авран хамгаалах, хор уршгийг нь арилгах үйл хэрэгт жинтэй хувь нэмэр оруулсаар байна. Тэрчлэн 1996 оноос Нидерландын Вант Улсын Гагаа хотноо Нобелийн Энх тайвны шагнал хүртсэн Химийн зэвсгийг хориглох олон улсын байгууллагын шинжээчээр бригадын генерал М.Хүрлээ, хурандаа З.Нармандах, Д.Эрдэнэцогт нар үүргээ амжилттай гүйцэтгэн, НҮБ-ын энхийг сахиулах болон олон улсын цэргийн ажиллагаанд анхлан үүрэг гүйцэтгэгчдийн тоонд химийн мэргэжлийн офицер, ахлагч нар зүй

ёсоор тооцогдож, даян дэлхийд энх амгаланг тогтоох үйл хэрэгт идэвхийлэн оролцсоор байна. Түүний зэрэгцээ химийн цэргийн анги, салбаруудын үүрэг гүйцэтгэх боломж, цэргийн сургалт бэлтгэлийн чанар, үр дүн улам бүр нэмэгдсэний зэрэгцээ энхийг дэмжих ажиллагаа, олон улсын сургалт, дадлагад амжилттай үүрэг гүйцэтгэж байгааг Зэвсэгт хүчний удирдлага ямагт өндрөөр үнэлдэг юм.

Цаашид төрийн цэргийн шинэчлэлийн бодлогыг хэрэгжүүлэх, химийн цэргийн анги, салбарууд, бие бүрэлдэхүүний дадлага, мэргэжлийн ур чадварыг дээшлүүлэх, цэргийн сургалт бэлтгэлийн чанарыг ахиулах, цэргийн алба, сахилга, дэг журмыг бэхжүүлэх, материал, техникийн хангалт, орчин нөхцөлийг сайжруулах үйл хэрэгт ихээхэн амжилт олно гэдэгт итгэл төгс байна.

Эрхэм Та бүхэндээ дахин баярын мэндчилгээ дэвшүүлж, ажил үйлсэд тань арвин их амжилт, амьдралд тань аз жаргал, эрүүл энх, сайн сайхан бүхнийг бэлгэдэн ерөөе.

Монгол цэргийн яруу алдар, сүр хүч, сүлд хийморь мандан бадрах болтугай

Монгол Улсынхаа эрх чөлөө, тусгаар тогтнол, хөгжил дэвшлийн төлөө залуу нас, хөдөлмөр зүтгэлээ зориулсан бэлтгэл болон чөлөөнд байгаа ахмад дайчид, өдгөө химийн цэргийн алдар гавьяа, амжилт бүтээлийг нэр төртэйгөөр залгамжлан яваа эрхэм генерал, офицер, ахлагч, түрүүч, байлдагч, ажилтан албан хаагч Та бүхэнд Химийн цэрэг үүсэн байгуулагдсаны

86 жилийн ойн баярын мэндийг өргөн дэвшүүлье.

Бүгд Найрамдах Монгол Ард Улсын Цэргийн явдлын яамны сайд бөгөөд Бүх цэргийн Жанжны 1936 оны 6 дугаар сарын 27-ны өдрийн 101 дүгээр тушаалаар Монгол Ардын Хувьсгалт Цэргийн үндсэн нэгтгэлүүдэд химийн салаадыг байгуулан орон тоо, хими хамгаалалтын техник, эд

ЗЭВСЭГТ ХҮЧНИЙ ЖАНЖИН ШТАБЫН ДАРГА ДЭСЛЭГЧ ГЕНЕРАЛ Д.ГАНЗОРИГ

ЦАГ АГААР

УЛААНБААТАР

ӨДӨР	ШӨНӨ
☀ 25	🌧 10


ӨМНӨД СУДАН

ӨДӨР	ШӨНӨ
☀ 36	🌧 25

ВАЛҮТЫН ХАНШ

ВАЛҮТ	АВАХ	ЗАРАХ
USD 🇺🇸	3.149.00	3.150.0
EUR 🇪🇺	3.3380.0	3.340.0
CNY 🇨🇳	471.50	473.00
RUB 🇷🇺	53.10	53.50
JPY 🇯🇵	23.40	23.70
KRW 🇰🇷	2.42	2.48

ЗУРХАЙ



2022.06.27 /ДАВАА ГАРАГ/
БИЛГИЙН ТООЛЛЫН 29

ЗУНЫ ИЛҮҮ ТЭРГҮҮН САРЫН ТАВАН ШАР МЭНГЭТЭЙ ЦАГААГЧИН ГАХАЙ ӨДӨР

Үс засуулбал:

Сүлд тэнэж одно

Наран ургах, шингэх:

04.55-20.55

Барилдлага:

Идэр

Шүтэн барилдлага:

Тийн мэдэхүй

Суудал: Хий

Энэ өдөр хонь, туулай жилтнээ аливаа үйлийг хийхэд эерэг сайн. Эл өдөр эе, эвээ ололцох, хамтын хөдөлмөр эхлэх, гэрээ хэлцэл байгуулах, найр хурим хийх, бэр гуйх, инж өгөх, авах, үнэт эрдэнийн зүйл авах, нялхсын хурим хийх, сүм дуганыг сэргээх, огторгуйн үүдийг боох, их хүмүүнтэй уулзахад сайн. Газар ухах, худаг гаргах, гөлөг тэжээх, балгадын суурь тавих, нохой худалдан авахад муу.

Өдрийн сайн цаг нь үхэр, луу, морь, хонь, нохой, гахай болой. Хол газар яваар одогсод урд зүгт мөрөө гаргавал зохистой. Үс шинээр үргээлгэх буюу засуулахад тохиромжгүй.

КОРОНАВИРУС ДЭЛХИЙ ДАХИНД

Тохиолдол

Нийт: 549,060,057

Эдгэрсэн

Нийт: 524,119,988

Нас барсан

Нийт: 6,351,017

Цахим шууданд

ТОМИЛГООТ БҮЛЭГ ХОЛЫН ЭРГҮҮЛИЙН ҮҮРЭГ ГҮЙЦЭТГЭВ



БНӨСУ-д НҮБ-ын энхийг сахиулах UNMISS ажиллагаанд үүрэг гүйцэтгэж буй Монгол Улсын Зэвсэгт хүчний мотобуудлагын батальоны хариуцлагын бүсэд цагийн байдал тогтвортой байгаа хэдий ч зарим суурин, сумдад зэвсэглэсэн залуусын хөдөлгөөн идэвхжин, малын хулгай, хүчингийн болон хүүхэд, эмэгтэйчүүдийг хулгайлах зэрэг гэмт хэргүүд гарсаар байна.

Иймд UNMISS ажиллагааны Хүчний командлагчийн төлөвлөгөөний дагуу Юнити

секторын командлагчийн тушаалаар мотобуудлагын батальоны томилогдсон бүлэг энэ сарын 13-17-ны өдрүүдэд Маёом сумын нутагт холын эргүүл хийж, ажиллагааны түр баазыг байгуулан ажилласан юм.

Мотобуудлагын батальоны эргүүлийн бүлэг Маёом сумын удирдлагуудтай дөрвөн удаагийн уулзалтыг зохион байгуулж, мэдээлэл солилцлоо. Энэ үеэр тус сумын сургуулийн удирдлагуудтай уулзан, хүүхдийн сурах боломжийг нэмэгдүүлэх зорилготойгоор

200 ширхэг дэвтэр, 100 ширхэг бал, 100 ширхэг харандаа, 50 ширхэг үзүүлэн таниулах хэрэгсэл, 300 ширхэг гар ариутгагч, 1000 ширхэг амны хаалт, 200 ширхэг дархлаа дэмжих витаминь тус тус хандивласан нь тэдний талархлыг хүлээв.

Мөн ундны усаа авах боломжгүй өндөр настай хүмүүс болон зарим иргэдэд хөдөлгөөнт ус түгээлтийн арга хэмжээг зохион явуулсан нь чухал ач холбогдолтой ажил болсон юм.

Ахлах дэслэгч П.БАЯЛАГМАА



УУЛЧИН ДАЙЧИД “АЛЬПИНИАД-2022” ӨНДӨР УУЛАНД АВИАЛТЫН ХЭЭРИЙН СУРГАЛТ ЦУГЛАРАЛТАД ХАМРАГДЛАА

Зэвсэгт хүчний 331 дүгээр анги

Монголын уулчдын үндэсний холбооноос зохион байгуулсан “Альпиниад-2022” өндөр ууланд авиралтын хэерийн сургалт, цугларалтад тус ангиас захирагчийн орлогч дэд хурандаа Э.Баянбат, ахлагч Ч.Пэлжид, дэд ахлагч Б.Батбаяр, П.Бөхболд нар энэ сарын 21-26-ны өдрүүдэд хамрагдлаа.

Баян-Өлгий аймаг дахь Алтай таван богдын районд явагдсан тус



сургалт, цугларалтад уулын спортын нийт 25 клубийн 280 гаруй ууланд

авирагчид оролцож уулын анхан шатны сургалт, 20 км-ын уулын кросс

гүйлтийн тэмцээн, малчин болон хүйтний оргилуудад авирах арга хэмжээнүүд явагдсан юм. Энэ хүрээнд 21-нд зохион байгуулсан 20 км-ын уулын кросс гүйлтийн тэмцээнд ахлагч Ч.Пэлжид, дэд ахлагч Б.Батбаяр нар амжилттай оролцож шагналт байранд шалгарсан бол 22-нд малчин /4051м/ оргилд дэд хурандаа Э.Баянбат, ахлагч Ч.Пэлжид, Б.Батбаяр, П.Бөхболд нар амжилттай оргилдож, батламжлагдсан юм.

ЗАМ ТЭЭВРИЙН ОСЛООС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ ЧИГЛЭЛЭЭР СУРГАЛТАД ХАМРАГДАВ



Зэвсэгт хүчний 110 дугаар анги

Зэвсэгт Хүчний Жанжин штабын “Дэг журам, сахилга хариуцлагыг бэхжүүлэх салбар зөвлөл”-ийн албан даалгаврын хүрээнд Зам тээврийн ослоос урьдчилан сэргийлэх зорилгоор Орхон аймгийн Цагдаагийн газрын Тээврийн цагдаагийн албатай хамтран “Аажуу явбал аяндаа хүрнэ” арга хэмжээнд Зэвсэгт хүчний 110 дугаар ангийн бие бүрэлдэхүүн нэгдэв.


Аяны хүрээнд Зэвсэгт

хүчний Тээврийн хяналтын зохицуулагч ахлах дэслэгч Л.Зоригтбаатар энэ сарын 24-ний өдөр сургалт зохион байгуулав. Сургалтаар орон нутгийн замд гарч буй зам тээврийн ослын гол шалтгаан нөхцөл нь хурд хэтрүүлэх, гүйцэж түрүүлэх үйлдэл хориглосон нөхцөлд хийх, бүрэн бус тээврийн хэрэгсэлтэй хол замд гарах, жолоочийн нойр дутуу ядарсан, архи согтууруулах ундааны зүйл хэрэглэсэн, жолооч биш хүнд жолоо шилжүүлэх зэргийг бие

бүрэлдэхүүнд анхааруулж гэмт хэрэг, осол, зөрчлөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээг хэрэгжүүлэн ажиллалаа.

Сонирхулахад, тээврийн цагдаагийн албанаас хийсэн судалгаагаар Монгол Улсад зам тээврийн ослоор сүүлийн 10 жилийн хугацаанд 4593 иргэн амь насаа алдаж, 11212 иргэн гэмтэж хөдөлмөрийн чадвараа алдсан байна.

Ахлах дэслэгч Д.ДАВААЖАРГАЛ



ЦЭРГИЙН ЧУУЛГЫНХАН “ЦАГААН НӨМРӨГТНҮҮД-2022” ТЭМЦЭЭНД УРАН БҮТЭЭЛЭЭ ТОЛИЛУУЛЛАА

ЦДБЭЧ

Монголын хүн амын эрүүл мэндийн салбарт хүчин зүтгэж буй эмнэлгүүдийн эмч, сувилагч, ажилтан алба хаагчдын дундах 6 төрөлт спортын аварга шалгаруулах “Цагаан нөмрөгтнүүд-2022” тэмцээн энэ өдөр нээлтээ хийж Цэргийн дуу бүжгийн Эрдмийн чуулгын уран бүтээлч хамт олон дэмжлэг үзүүлэн ажиллаж урлагийн мэндчилгээнүүдийг дэвшүүлээ.

Эрүүл мэндийн яам,

Цэргийн төв эмнэлэг, Улсын нэгдүгээр эмнэлэг, Хавдар судлалын үндэсний төв, Эх, хүүхдийн эрүүл мэндийн үндэсний төв, “Өргөө” амаржих газар тэргүүтэй нийт 27 байгууллагын хамтран зохион байгуулж буй тус нөхөрсөг тэмцээнд чуулгын уран бүтээлчид, “Монгол Улсын Төрийн дуулал”-аа хүндэтгэлтэйгээр эгшиглүүлэн, “Сувилагчдын бүжиг”-ээр цагаан нөмрөгт баатруудаа алдаршуулж, “Тамирчны алдар”-

ыг бахдан дууллаа.

Тус тэмцээнд ЦДБЭЧ-ын уран бүтээлчид урлагийн мэндчилгээ дэвшүүлсэн төдийгүй ЗХЖШ-ын Үлгэр жишээ үлээвэр найрал хөгжим, Зэвсэгт хүчний 032 дугаар ангийн хүндэт харуулын “Жагсаалын үзүүлэх тоглолт”, Зэвсэгт хүчний 084 дүгээр ангийн “Гардан тулаан”-ы үзүүлэх тоглолтыг баг тамирчдад сонирхуулсан нь салбарын үйл ажиллагааг тодотгон харуулсан онцлогтой нээлтийн арга хэмжээ болсон юм.

